

“Граунд Гольфийн олон улсын тэмцээн Юрихама 2018”
ТЭМЦЭЭН ЗОХИОН ЯВУУЛАХ ЖУРАМ
2018 Yurihama International Ground Golf Open

1. Зорилго

Бага балчираас ахмад настан хүртэл бүх насны хүмүүс тоглож наадах боломжтой Граунд гольф нь, Тоттори мужийн Юрихама сумаас гаралтай бөгөөд уг спортыг дэлгэрүүлж хөгжүүлэх, тоглогчидын хил дамнасан харилцааг хөгжүүлэх, “World Masters Games 2021 Кансай” олон улсын спортын наадмын хүрээнд дэлхийн хэмжээний тэмцээнийг нутагтаа зохион байгуулахыг зорьж байна.

2. Зохион байгуулагч

Олон улсын граунд гольфийн тэмцээнийг зохион байгуулах хороо

3. Хамтран зохион байгуулагч

Тоттори мужийн захиргаа, Юрихама сумын захиргаа

4. Хамтран зохион байгуулагч (урьдчилсан байдлаар)

Нийтийн ашгийн төлөөх хуулийн этгээд Японы граунд гольфийн нийгэмлэг, Тоттори мужийн граунд гольфийн нийгэмлэг, Тоттори мужийн захиргаа, Тоттори мужийн Боловсролын хороо, Нийтийн ашгийн төлөөх хуулийн этгээд Тоттори мужийн Олон улсын харилцааны сан, Шин Нихонкай сонины компани, NHK Тоттори телевиз, Хавай халуун рашаан Того халуун рашаант буудлын хоршоолол, Юрихама сумын захиргаа, Юрихама сумын Боловсролын хороо, Юрихама сумын Олон улсын харилцааны нийгэмлэг, Юрихама сумын Биеийн тамирын нийгэмлэг, Юрихама сумын Спорт хөгжлийн хорооны зөвлөл

5. Ивээн тэтгэгч (урьдчилсан байдлаар)

ASICS JAPAN ХК, CHUBU ХК

6. Хугацаа

2018 оны 5 сарын 19 (Бя), 20 (Ня)-ны өдөр ✖Бороотой цаг агаартай байсан ч тэмцээн явагдана

7. Газар

Тоттори муж Тохаку тойргийн Юрихама сум 1313

Граунд гольфийн Фүрусато цэцэрлэг – Шиоказэно Ока Томари

8. Хөтөлбөр:

Эхний өдөр: 5 сарын 19-ний өдөр (Бя) Бүртгэл 08:20 – 08:50

Нээлтийн ажиллагаа 09:00 – 09:40

Тоглолт 10:00 – 15:30

(※ Эхний өдрийн тоглолт дууссаны дараа улс, бүс нутгуудын төлөөлөл санал солилцох уулзалттай)

Удаах өдөр: 5 сарын 20-ны өдөр (Ня) Бүртгэл 09:00 – 09:30

Тоглолт 10:00 – 11:40

Өдрийн хоол 11:40 – 12:20

Шагнал гардуулах,

хаалтын ажиллагаа 12:30 -13:00

Сугалаа 13:00 – 13:30

9. Оролцох хүний тоо 384 оролцогч

(Гадаад оролцогч 192 хүн, Японоос оролцогч 192 хүн. Тогтоосон тооноос илүү гарсан тохиолдолд гадаадаас оролцогчдыг шийдвэрлэсний дараа, дотоодоос оролцогчдыг сугалаа сугалж оролцох эрхийг олгоно)

10. Тэмцээнд оролцох төлбөр: 1 хүн 2,000 иен (үүнд 2 өдрийн өдрийн хоол (бэлэн хоол бэнто) орно). Төлбөрийг бүртгүүлэхдээ бэлнээр төлнө.

11. Тоглолтын дүрэм: Нийтийн ашгийн төлөөх хуулийн этгээд Японы граунд гольфийн нийгэмлэгийн дүрмээр явагдана.

12. Тоглох аргачлал:

Эхний өдөр 5 сарын 19 (Бя) – дотор талбай, гадаад талбай, тохойн талбай, өргөн талбай дахь маршрут бүрийн 8 нүхнээс 3 маршрут 24 нүхээр тойрч тоглоно.

Удаах өдөр 5 сарыг 20 (Ня)– дотор талбай, гадаад талбай, тохойн талбай, өргөн талбай дахь маршрутаас эхний өдөр тойрсон маршрутаас өөр нэг маршрутын 8 нүхээр тойрч тоглоно. Ганцаарчилсан тоглолт байх ба 4 раунд тоглосон нийт онооны дарааллаар байр эзлүүлнэ.

13. Шагнал

① Гадаад оролцогч: 1 – 6 байр пайз, дурсгалын зүйл

Японы оролцогч: 1 – 6 байр пайз, дурсгалын зүйл

② Тусгай шагнал: Тусгай шагнал: нэг цохилтоор бөмбөг оруулсан шагнал

14. Бүртгэл

Бүртгэлийн хуудас дээр шаардлагатай мэдээллүүдийг бөглөж, заасан хугацаанаас өмнө ирүүлнэ.

Бүртгүүлэх хаяг, лавлах хаяг

19 – 1 Hisadome, Tohakugun Yurihama-cho, Tottori, 682 – 0723

Олон улсын граунд гольфийн тэмцээнийг зохион байгуулах хороо

E-mail : groundgolf@yurihama.jp

TEL : 0858 – 35 – 5368

FAX : 0858 – 35 – 5387

15. Бүртгэлийн хугацаа: 2018 оны 3 сарын 30-ны (Ба) өдрөөс өмнө

16. Бусад

- ① Нийтийн ашгийн төлөөх хуулийн этгээд Японы граунд гольфийн нийгэмлэгээс батламжилсан цохиур бөмбөгийг хэрэглэнэ. Батламжилсан хэрэгслээс өөр цохиур бөмбөг хэрэглэсэн тохиолдолд үүссэн осол гэмтлийг хэрэглэгчийн өөрийн хариуцлагад тооцох ба зохион байгуулагч тал хариуцлага үл үүрнэ. Хэрэгсэл шаардлагатай хүнд зохион байгуулагч тал хэрэгслийг үнэгүй зээлүүлж хэрэглүүлнэ.
- ② Тэмдгийг оролцогчид өөрсдөө авч ирнэ. Оролцогчийн шагнал болгож өгөх тэмдгийг хэрэглэсэн ч болно.
- ③ Зохион байгуулагч спортын даатгалд хамрагдана.
- ④ Тоглолтын үеэр осол гэмтэл гарсан гарсан тохиолдолд яаралтай тусламжийг үзүүлэх боловч түүнээс хойшхи хариуцлагыг даатгалаас хариуцна.
- ⑤ Өдрийн хоолыг зохион байгуулагч талаас бэлэн хоол буюу бэнто бэлдэнэ.
- ⑥ Цаг агаар муу тохиолдолд хөтөлбөрт өөрчлөлт орох тохиолдол байна.
- ⑦ Нийт оролцогчид оролцогчийн батламж гардуулна.
- ⑧ Уг журамд зааснаас бусад нөхцөл байдал үүссэн тохиолдолд зохион байгуулагч шийдвэрлэнэ.
- ⑨ Оролцогчдын харилцааны арга хэмжээг 2018 оны 5 сарын 18-ны өдөр (Ба) 17:00 цагаас зохион байгуулна. (урьдчилсан байдлаар)
- ⑩ Тус зохион байгуулах хороогоор дамжуулж Хавай, Того халуун рашаантай буудалд байрлах тохиолдолд 1 хоногт 1 хүн тутамд 5,000 иений хөнгөлөлт үзүүлнэ. (хавсралтаас үзнэ үү)